

Онол, арга зүйн сэтгүүлд нийтлэх бүтээлд тавих шаардлага

Сэтгүүлийн нийтлэлийн бодлогод хамаарах агуулгын хүрээнд бичигдсэн дараах шаардлагыг хангасан бүтээл нийтлэгдэнэ. Үүнд:

1. Бүтээл

1.1.Бүтээл нь дараах хэлбэртэй байж болно:

- а. Эрдэм шинжилгээний өгүүлэл;
- б. Судалгааны үр дүн, тойм;
- в. Бүтээлийн шүүмж;
- г. Шинжлэх ухааны тайлбар;
- д. Эх сурвалж, орчуулга.

1.2.бүтээл нь дүгнэлт, саналтай байна.

2.Эрдэм шинжилгээний өгүүлэл

2.1.Эрдэм шинжилгээний өгүүлэл нь дараах бүтэцтэй байна. Үүнд:

- Гарчиг /Монгол, англи хэл дээр/
- Зохиогчийн нэр, харьяа байгууллага /Монгол, англи хэл дээр/
- Хураангуй /Монгол, англи хэл дээр/
- Түлхүүр үгс /Монгол, англи хэл дээр/
- Үндэслэл
- Үндсэн хэсэг
- Дүгнэлт, санал;
- Эх сурвалж;
- Хавсралт;

2.2.эрдэм шинжилгээний өгүүлэл нь эшлэл, тайлбарыг оролцуулан 2500- 4500 (ойролцоогоор 6-15 нүүр) үгтэй байх ба үндсэн хэсэгт судлагдсан байдал, үр дүн, хэлцэмж бичигдэнэ;

2.3.Хураангуй нь судалгааны хэрэгцээ шаардлага, зорилго, үндсэн арга зүй, гол үр дүн, үндсэн дүгнэлт, судалгааны шинэлэг тал, тухайн салбарт үзүүлэх ач холбогдол зэрэг агуулгыг багтаасан 150-200 үгтэй байна;

2.4.түлхүүр үгст тухай өгүүллийн цөм утгыг агуулсан 4-өөс 5 хүртэл үг бичигдэнэ;

2.5.гарчиг, зохиогчийн нэр, харьяа байгууллага, түлхүүр үгсийг монгол, англи хэлээр 150 үгэнд багтаана;

2.6.эшлэлд авагдсан бүтээл эх сурвалжид бичигдэнэ;

2.6.эрдэм шинжилгээний өгүүллийг редакцын зөвшөөрлөөр англи, орос хэлээр хэвлэж болно;

3. Судалгааны үр дүн, тойм

3.1.судалгааны үр дүн, тойм гэдэгт аюулгүй байдал, дотоод хэргийн үйл ажиллагааны чиглэлээр хийгдсэн эрдэм шинжилгээ, судалгааны ажлын үр дүн-тайлан, танилцуулга, тойм, хураангуй зэргийг хамруулна.

3.2. судалгааны үр дүн нь нь 1500-5000 үгтэй байна.

3.3. тухайн сэдвээр судлаачдын бүтээл, номлолоос эшлэл авсан байна.

4. Бүтээлийн шүүмж

4.1.бүтээлийн шүүмжийг тухайн салбарын эрдэмтэн, судлаач бичсэн байна.

4.2.шүүмж нь тухайн бүтээлийн шинжлэх ухаанд оруулж байгаа хувь нэмрийг сайшаах бус өмнөх бүтээл, эрх зүйн номлол, шийдвэр, практикийг хэрхэн өөрчилж

байгааг харуулсан байна.

4.3.шүүмжийг бүтээл хэвлэгдсэнээс хойш 6-аас доошгүй сарын дараа нийтэлж болно.

4.4.бүтээлийн шүүмж нь 1000-3500 үгтэй байна.

5. Шинжлэх ухааны тайлбар;

5.1.эрдэм шинжилгээний сэтгүүлд хэвлэн нийтлэх ач холбогдлыг нэн тэргүүнд харгалзан үзэж ховор, нэн шаардлагатай материалын эх сурвалж, орчуулгыг зэргийг лавлагаа мэдээлэл хэлбэрээр нийтэлж болно.

5.2.сэтгүүлийн нэг удаагийн дугаарт нэгээс илүүгүй лавлагаа мэдээлэл байж болно.

5.3.редакц лавлагаа мэдээллийн үнэн зөв эсэхийг нягтлах бөгөөд нийтлэхээс татгалзах эрхтэй.

5.4.лавлагаа мэдээллийг ирүүлэхдээ эх материалыг хаана, хэзээ хэвлэгдсэнийг таньж болохуйц байдлаар хавсарган редакцад ирүүлэх бөгөөд зохиогчийн эрхийг хүндэтгэн үзсэн байна.

6.Бүтээлд тавих ерөнхий шаардлага

6.1.сэтгүүлд нийтлүүлэхээр ирүүлж байгаа бүтээл өмнө нь ямар нэгэн байдлаар нийтлэгдээгүй байна.

6.2.хянан магадалгаа хийлгэх болон хуулбарлалтын программд уншуулах төлбөр төлсөн баримтыг хавсаргана.

6.3.бүтээл нь хэл зүй, найруулгын хувьд эрдэм шинжилгээний нийтлэлийн шаардлагыг хангасан байх ба зарим гадаад нэр томьёог галигласан тохиолдолд хаалтад тухайн гадаад хэл дээрх нэр томьёог оруулна.

6.4.бүтээлд зохиогчийн нэр, хаана ямар ажил эрхэлдэг, эрдмийн зэрэг, цол зэргийг монгол, англи хэлээр ирүүлнэ.

6.5.үндсэн бичвэрийн цаасны хэмжээг B5 (176x250mm), бүх талаас 2cm байхаар сонгон, сэдвийн гарчиг, үндсэн бичвэр Times New Roman 11pt, мөр хоорондын зай 1/single/, эшлэл, зүүлт, хүснэгт, график, зургийн үгсийн хэмжээ Times New Roman 9pt, догол мөр 1cm байх ба файлын өргөтгөл “.docx” байна.

6.6.эшлэл, эх сурвалжийг APA загвараар бичнэ.

6.7.хүснэгт, зураг, график, схем дугаарлалт, тайлбарыг тухайн зураг, график, схемийн доор голлуулж оруулна.

6.8.бүтээл нь редакц өөрөөр шийдвэрлэснээс бусад тохиолдолд монгол хэлээр бичигдсэн байна. Эдгээрээс бусад шалгуураар сэтгүүлд хэвлэх эсэхийг редакц шийдвэрлэх эрхтэй байна.